



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1.	Оршил .....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар .....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
	Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн зөвлөмж	
	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын түүвэрт хамрагдсан байгууллагад өгсөн зөвлөмж	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	
4.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	17
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21
6.	Албан шаардлага, төлбөрийн акт .....	29

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 863  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Сумъяабазар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд аудитын дүнд үндэслэсэн Төсвийн ерөнхийлөн захирагчид салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөх, үе шатны ажлыг хэсэгчилсэн хийсэн геологийн болон хөрөнгө оруулалтын төсөв захирагчид санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох 6 зөвлөмжийг тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-аас 2019 оны 4 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Эрдэнэзул хийж гүйцэтгэв.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 1/969 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.





Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим, сорилыг хэрэгжүүлэн, чанарын хяналт хийлгэж, холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан, баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

УУХҮЯ-ны талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар 05-ны өдрийн 370 дугаар тогтоолоор “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталж, эрхэм зорилгоо “Ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоход оршино” гэж тодорхойлон, үйл ажиллагааны 9 чиглэлийг баталсан байна.

УУХҮС Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль,
- Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, заавар,
- Холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар 05-ны өдрийн 370 дугаар тогтоолоор “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталсан байна.
- Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолын 4 дүгээр заалтаар “Эрдэнэставан толгой” ХК байгуулах тухай Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолын нэгдүгээр зүйлийн “Эрдэнэс Монгол ХХК”-ийн охин компанийн хэлбэрээр” гэсэн хэсэг хасагдсан.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг



шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн “Э-Тайлан” програм хангамжийг ашиглаж байна.

Санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

УУХҮЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Геологийн төв лаборатори, Геологийн судалгааны төв төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2016-2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологи хайгуулын төслийн хэрэгжилтэд санхүүгийн болон нийцлийн аудитыг хийж нийт 25 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад УУХҮС-ын эрхлэх хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгов.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонгосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөөгүй болно.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,165,762.8 сая төгрөгийн 1 хувь буюу 11,657.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурь үзүүлэлт болон, хувь хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд 2018 оны жилийн САГ-2019/28/СТА-ТЕЗ



эцсийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,457,478.1 сая төгрөгийн 1 хувь буюу 24,574.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд эрсдэлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад санал дүгнэлт гаргаж, геологийн болон хөрөнгийн зардлын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй болно.

Монгол Улс болон Швейцарийн Холбооны Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн дагуу Швейцарийн талын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн санхүүгийн тайланд олон улсын аудит хийддэг, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн програмд шууд нэгтгүүлдэг, аудит хийх шаардлагатай баримт материалыг Швейцарийн хөгжлийн агентлагт албан ёсоор хандаж авах шаардлагатай зэрэг нөхцөл байдлын улмаас аудитад хамруулаагүй болно.

### Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн аудитын хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	2		
2	Төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллага	12			
3	Тогтвортой бичил уурай төсөл				1
4	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
Дүн		15	2	0	1

Эх сурвалж: Аудит хийсэн тайлан.

Аудитад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудаас “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”, “Эрдэнэставан толгой” ХК, “Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ зэрэг 3 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, бусад 11 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 81,335.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 12.5 хувь буюу 10,174.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 74.9 хувь буюу 60,931.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах зөвлөмж, 12.5 хувь буюу 10,176.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүрүүлж, 53.1 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд 1,551.1 сая төгрөгийн, төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд 2,107.2 сая төгрөгийн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 6,516.4 сая төгрөгийн нийт 10,174.7 сая төгрөгийн алдааг залруулсан болно.





УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. Алдаа, зөрчил түүний шийдвэрлэлт.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	17	14,109.2			4	9,171.2	13	4,938.0				
2	ТӨААНБ	44	13,473.7	3	13.4	3	1,005.0	38	12,455.3				
3	Түүвэрт хамрагдсан	8	43,577.6	2	39.7			6	43,537.9				
4	ТЕЗ	2				1		1					
	<b>Дүн</b>	<b>71</b>	<b>71,160.5</b>	<b>5</b>	<b>53.1</b>	<b>8</b>	<b>10,176.2</b>	<b>58</b>	<b>60,931.2</b>				

Эх сурвалж: Аудит хийсэн тайлан.

### 2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний 14 аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргаснаас нийт 27,582.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 13.4 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх 3 төлбөрийн акт, 10,176.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 7 албан шаардлага, 17,393.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 51 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын түүвэрт хамрагдсан геологийн болон хөрөнгө оруулалтын зардлын санхүүгийн тайланд нийт 43,577.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 39.7 сая төгрөгийн 2 акт, 43,537.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүлсэн болно.

### 2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар геологийн болон хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүвэрт хамруулан, дүнг нэгтгэн тайлагналаа.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 11 чиглэлээр 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 12 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.



УУХҮС-дад менежментийн захидлаар 1 зөвлөмж хүргүүлж байгаа бөгөөд хязгаарлалттай санал дүгнэлт авсан болон төсвийн тухай хуулийн дагуу Үндэсний аудитын газарт жилийн эцсийн санхүүгийн тайлан ирүүлээгүй нийт 7 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад хариуцлага тооцуулахаар 1 албан шаардлага хүргүүлж байна.

Мөн түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан бөгөөд бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **Асуудал 1: Орлого төвлөрүүлэлт**

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд он дамжсан, зориулалт тодорхойгүй 39.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасныг тус тус зөрчиж байна.

**Шийдэл:** Дээрх орлогыг улсын төсөвт татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

### **Асуудал 2: Зардлын гүйцэтгэл**

Геологи судалгааны ажлын аргачлал, хяналтаар ажиллах албан томилолтын зардлыг 0.7 сая төгрөгөөр илүү бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдэл:** Илүү олгосон зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Аудитын явцад анхаарал татахуйц, Төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд хандуулах, Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг байдлаар нөлөөлөхүйц дараах асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор “Эрдэнэставан толгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны эзэмшигчийн эрхийг УУХҮЯ, ТӨБЗГ-т шилжүүлж, “Эрдэнэс Монгол” ХК-ийн охин компани байсныг хүчингүй болгосон байна. Уг тогтоолын дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төрийн өмчийн хувьцааг эзэмших, бүртгэх эрх дуусвар болсон ч 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өөрчлөлт оруулаагүй;
2. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлдэг өөрийн орлогоос УУХҮЯ-ны сайдын тушаалаар тус яамны болон геологи судалгааны ажлын төсөвт 4,850.0 сая төгрөгийг “Туслах үйл ажиллагааны орлого”-д тооцон, төсөвт батлагдаагүй 4,600.0 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т “Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална: 33.2.4-т “бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг”, 41 дүгээр зүйлийн 41.2-т заасан бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар хүлээх үүрэгт заасныг тус тус зөрчсөн;
3. Мөн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2.1-д “Орлого гэдэг нь тайлангийн хугацаанд байгууллагын ердийн үйл ажиллагааны үр дүнд орж ирж байгаа бөгөөд өмчлөгчдөөс оруулах нэмэгдэл хөрөнгө



оруулалтаас бусад цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхаас орох нийт орлогын урсгал юм" гэж заасантай нийцэхгүй;

4. "Эрдэнэставан толгой" ХК-ийн Зүүн цанхийн олборлогч "Ти Ти Жэй Ви Си Өү" ХХК-тай хийсэн гэрээнд анхаарал татахуйц дараах асуудлууд байна. Үүнд:

- Уг гэрээг ам.доллараар хийсэн нь 2009 онд батлагдсан "Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай" хуулийн заалтад нийцэхгүй;
- 2015 онд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний 7.6 дахь заалтад үнийн өөрчлөлтийн зөрүүг жил бүр тооцож уулын ажлын үнэнд тохируулга хийхээр заасан нь ихээхэн хэмжээний алдагдал хүлээж байна. 2018 онд ам.долларын ханш дахин чангарч 9.1 сая ам.долларын өсгөх тохируулга хийгдэхээр тооцоолсон;
- 2018 онд "Ти Ти Жэй Ви Си Өү" ХХК нь өсгөх тохируулга хийсэн 9.1 сая ам.доллар буюу 24.1 тэрбум орчим төгрөгийг харилцан тохиролцоонд хүрч чадахгүй, маргаантай;
- Баруун цанхийн олборлогч компаниуд 1 м3 хөрсийг ойролцоогоор НӨАТ шингээгүй үнэ буюу 5,800 төгрөгөөр олборлодог байтал "Ти Ти Жэй Ви Си Өү" ХХК нь 3.99 ам.доллар буюу 10,500 төгрөгөөр буюу ойролцоогоор 2 дахин илүү үнээр олборлож байна.

5. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар тогтоолоор "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030", "Алт 2 хөтөлбөр"-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий "Эрдэнэс Алт ресурс" ХХК-ийг байгуулсан байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 5 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан улсын төсвөөс 18,918.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогод 2,680.8 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогод 4,797.4 сая төгрөгийг бүрдүүлж нийт 26,397.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Зардлын нийт гүйцэтгэл 25,012.4 сая төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь хөрөнгийн санхүүжилт 356.9 сая төгрөгөөр дутуу санхүүжигдэж, орлогын төлөвлөгөө 1,019.6 сая төгрөгөөр тасарснаас шалтгаалан хөрөнгийн болон сургалтын урамшууллын зардлын гүйцэтгэл дутуу гарсантай холбоотой байна.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэмэлт санхүүжилтээр нийт 401.4 сая төгрөгийн санхүүжилт төвлөрч, 338.5 сая төгрөгийг зарцуулан 63.9 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Үндэсний аудитын газраас "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллагад дараах 8,190.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэхээр хүлээн зөвшөөрүүлсэн байна. Үүнд:



- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй,
- Хөрөнгө захиран зарцуулах шийдвэрүүдийг мэдээлээгүй,
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус сайдын харьяа бус байгууллагуудыг мэдээлсэн,
- Зарим байгууллага цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг дутуу оруулсан,
- Зарим мэдээллийг хугацаа хоцроосон.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 16 аж ахуйн нэгж, байгууллага, төслийн нэгж хамрагдаж нийт 50 зөвлөмж хүргүүлснийг 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтүүдээс авч үзэхэд 91.9 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав. Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



### **3 Менежментийн захидал /Төсвийн ерөнхийлөн захирагчид/**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

УУХҮЯ-ны салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөөгүй байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Салбарын хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлого алдагдаж, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, мөрдөж ажиллах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.





## **Менежментийн захидал /Түүвэрт хамрагдсан геологийн болон хөрөнгийн зардлын тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой/**

### **3.1 Биет бус хөрөнгө**

#### 3.1.1 Илрүүлэлт:

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 37,139.5 сая төгрөгийн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлангуудыг урьдчилгаа тооцоогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын Эрх ба үүрэг, "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлүүд болон УСНББОУС 31-ийн 28-д "Биет бус хөрөнгийг дараах тохиолдолд л хүлээн зөвшөөрнө: а) Хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхыг байгууллага хүртэх магадлалтай; б) Хөрөнгийн өртгийг эсвэл бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжих боломжтой бол" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж хэрэглэгчдэд зөрүүтэй мэдээлэл хүрэх.

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Геологийн судалгааны ажлын урьдчилгаа тооцоог анхан шатны баримт материалыг үндэслэн бусад эргэлтийн хөрөнгөнд орлого авч, эзэмшигч байгууллагад шилжүүлэн өгөх.

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

### **3.2 Өмчийн өөрчлөлтийн тайлан**

#### 3.2.1 Илрүүлэлт:

Геологийн судалгааны ажлын болон хөрөнгө оруулалтын зардлын өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капитал дансанд нийт 6,386.7 сая төгрөгийн хөрөнгө хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ УСНББОУС 12-ийн 11-т "Бараа материал худалдан авсан болон дахин борлуулахаар эзэмшиж байгаа бараа, борлуулахаар эзэмшиж байгаа газар болон бусад үл хөдлөх хөрөнгө орно", Сангийн сайдын 2013 оны 69 дүгээр тушаалын 1 дүгээр зүйлд "Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь орлогоор бүртгэнэ. Дт.Үндсэн хөрөнгө Кт.Орлого" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж хэрэглэгчдэд зөрүүтэй мэдээлэл хүрэх.

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Өмчийн өөрчлөлтийн тайлан дахь Засгийн газрын оруулсан капитал дансанд илэрхийлэгдсэн хөрөнгийн дүнд залруулга хийх.

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

### **3.3 Авлага, өр төлбөр**

#### 3.3.1 Илрүүлэлт:

Геологийн байгууллага болон хөрөнгө оруулалтын зардлын нягтлан бодох бүртгэлд өглөг, авлагын дэлгэрэнгүй журналыг бодитой хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн



тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3.Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.3.2 Эрсдэл:

Харилцагч байгууллагуудын ажил гүйлгээ, үлдэгдэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй болж гүйцэтгэлийг илүү, дутуу олгох.

#### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Өглөг, авлагын дэлгэрэнгүй журналыг анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв хөтөлж байх.

#### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

### 3.4 Мөнгөн хөрөнгө

#### 3.4.1 Илрүүлэлт:

Касст хэрэгцээ, шаардлагаас илүү бэлэн мөнгө авсан, эхний хагас жилээс эхлэн хэмнэгдсэн 11.7 сая төгрөгийн үлдэгдлийг харилцахад буцаан тушаагаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5-д “Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид “ЖМС” гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.4.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй, зориулалт бусаар зарцуулагдах.

#### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Кассын ажиллагааны журмыг мөрдөж, бэлэн мөнгөний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

### 3.5 Эргэлтийн хөрөнгө

#### 3.5.1 Илрүүлэлт:

Геологийн судалгааны ажлын болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн хөрөнгийг захиалагчийн санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, ашиглагч байгууллагад шилжүүлэх бүртгэл хийгээгүй байна.

Энэ нь УСНББОУС-12 “Бараа материал”-ын 9-д “Бараа материалд дараах хөрөнгө орно: в) Үйл ажиллагааны хэвийн үед борлуулах буюу хуваарилахаар эзэмшиж байгаа хөрөнгө” гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.5.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй зарцуулагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Геологийн судалгааны ажлын болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөөр бүртгэж, холбогдох шийдвэр, баримт материалыг бүрдүүлсний үндсэн дээр ашиглагч байгууллагад бүртгэлээр шилжүүлэн, хүлээлгэн өгч байх.

### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

## 3.6 Мөнгөн хөрөнгө

### 3.6.1 Илрүүлэлт:

Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлаас зарцуулсан шатахууны зардалд жолоочийн тооцооны хуудас бөглүүлээгүй, албан томилолтын зардалд мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-тай тус тус нийцээгүй байна.

### 3.6.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй, зориулалт бусаар зарцуулагдах, санхүүгийн тайлан дахь зардал буруу илэрхийлэгдэж хэрэглэгчдэд зөрүүтэй мэдээлэл хүрэх.

### 3.6.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт материалыг иж бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг бүртгэлд тусгах, бэлэн мөнгөөр гарсан ажил гүйлгээ бүрд дараа тайлангийн тооцоо хийж байх.

### 3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	489,455,566.8	970,314,370.7
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	102,956,430.4	625,989,547.6
<b>АВЛАГА</b>	80,802,020.8	97,240,259.0
<b>УРЬДЧИЛГАА</b>	70,479,020.1	87,421,077.0
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	193,795,073.6	120,939,357.6
<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	23,175,390.4	23,175,390.4
<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	18,247,631.4	15,548,739.0
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	13,390,977,093.9	13,684,147,996.6
<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	1,555,484,540.0	1,725,640,137.4
Урт хугацаат зээл	1,555,484,540.0	1,725,640,137.4
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	11,835,492,554.0	11,958,507,859.2
<b>Биет хөрөнгө</b>	104,195,998.5	363,300,164.7
<b>Биет бус хөрөнгө</b>	11,352,706,078.2	11,194,754,697.0
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	378,590,477.3	400,452,997.4
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	13,880,432,660.7	14,654,462,367.3
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	1,001,204,570.8	787,780,366.8
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	537,299,441.7	444,564,165.2
Богино хугацаат зээлийн өглөг	121,756,500.0	86,892,720.8
<b>Өглөг</b>	263,165,479.1	239,864,086.5
Урьдчилж орсон орлого	152,377,462.6	117,807,358.0
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	463,905,129.1	343,216,201.6
Урт хугацаат зээл	463,905,129.1	343,216,201.6
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	12,879,228,090.0	13,866,682,000.5
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	12,879,228,090.0	13,866,682,000.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,670,462.0	16,878,631.6
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	19,935,089.3	21,569,211.6
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	134,190.0	137,190.0
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,197,207,710.0	11,197,207,710.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,555,268,146.7	1,732,221,764.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	88,517,036.2	889,483,991.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,495,455.8	9,183,502.0
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	13,880,432,660.7	14,654,462,367.3

## 4.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,159,671,336.2	1,696,311,729.0
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	44,026,124.9	42,666,881.8
Бусад татвар, төлбөр, хураамж	44,026,124.9	42,666,881.8
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,097,835,485.1	1,635,082,958.4
Нийтлэг татварын бус орлого	1,094,486,786.0	1,632,386,379.2
Тусламжийн орлого	3,348,699.1	2,696,579.3
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	17,809,726.2	18,561,888.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	638,472,226.2	884,830,090.4
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	638,472,226.2	883,181,062.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	372,113,429.1	603,298,815.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,847,049.6	3,566,346.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	469,207.0	436,108.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	361,534.5	246,828.3
Хангамж, бараа материалын зардал	472,267.9	350,159.4
Нормативт зардал	0.0	1,000.0
Эд хогшил, урсгал засварын зардал	195,274.9	107,097.7
Томилолт, зочны зардал	442,335.8	441,330.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,515,880.2	575,995,146.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5,809,879.1	22,154,798.0
<b>ХҮҮ</b>	3,653,420.8	0.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	262,705,376.4	279,882,246.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	0.0	1,649,028.5
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	521,199,110.0	811,481,638.6
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	863,276.1	29,404,615.5
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	31,670,467.7	4,404,884.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	490,391,918.4	836,481,370.0



### 4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,406,500,840.2	2,326,890,214.4
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	44,026,124.9	42,666,881.8
Бусад татвар, төлбөр, хураамж	44,026,124.9	42,666,881.8
Бусад нийтлэг төлбөр, хураамж	44,026,124.9	42,666,881.8
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,344,392,290.1	2,265,660,399.5
Нийтлэг татварын бус орлого	1,341,043,591.0	2,262,963,820.2
Тусламжийн орлого	3,348,699.1	2,696,579.3
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	18,082,425.2	18,562,933.1
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,099,055,687.1	1,517,084,015.6
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,099,055,687.1	1,517,084,015.6
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	834,139,281.5	1,237,092,923.3
